Их сургуулийн эрэгтэй оюутнуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн мэдлэгийг тодорхойлох нь

Б.Бадрангуй[1], Ж.Энхцэцэг[2], Д.Амарсайхан[1], Л.Баярмагнай[3], Л.Хоролсүрэн[4], Д.Оюунбилэг[5], Ж.Мядагмаа[1]

[1]АШУҮИС, НЭМС, Урьдчилан Сэргийлэх Анагаах Ухааны тэнхим
[2]АШУҮИС, АУС, Эх Барих, Эмэгтэйчүүдийн тэнхим
[3]АШУҮИС, НЭМС, Эпидемиологи, Биостатистикийн тэнхим
[4]АШУҮИС, НЭМС, Эрүүл Мэндийн Бодлогын тэнхим
[5]АШУҮИС, НЭМС, Эрүүл Мэндийн Нийгмийн Ажилтны тэнхим
Цахим хаяг: badraa59@gmail.com, Утас: 95140163, 99950077

Түлхүүр үг:

Жирэмслэлт
Үр хөндөлт
Бэлгийн харилцаа
Эрчүүдийн эрүүл мэнд

Товч утга:

Үндэслэл: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн (НҮЭМ) асуудалд дан ганц эмэгтэйчүүдийн оролцоо бус, эрчүүдийн оролцоо, тэдний гэр бүл төлөвлөлтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, мэдлэгийг нь дээшлүүлэх шаардлагатай байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Их сургуулийн 18-24 насны эрэгтэй оюутнуудын гэр бүл төлөвлөлт (ГБТ), НҮЭМ-н талаарх мэдлэгийг тодорхойлох. **Арга аргачлал:** Судалгааг агшингийн аргаар хийж гүйцэтгэн, судалгааны материалыг асуумжийн аргаар ДХИС, БХИС, ХААИС, АШУҮИС, МУИС, ШУТИС-н эрэгтэй оюутнуудаас онлайнаар авав. **Үр дүн:** Судалгаанд ИС-н 460 оюутан хамрагдсан бөгөөд дундаж нас 20.03 байв. Судалгаанд оролцогчдын 60.4% нь ганц бие, 4.6% гэрлэсэн ба 76.5% бэлгийн харилцаанд орсон байв. Бэлгийн харилцаанд орсон ба ороогүй хоёр бүлгийн нөхөн үржихүйн талаарх мэдлэгийн оноог харьцуулахад бэлгийн харилцаанд орсон бүлгийн 7.7% нь сайн, 47.7% нь дунд, 44.6% нь муу мэдлэгтэй байсан бол бэлгийн харилцаанд ороогүй бүлэг нь 60.2% нь хангалтгүй түвшний мэдлэгтэй байв (p=0.001). Судалгаанд оролцогчдын 56.1% нь эцэг эхтэйгээ НҮЭМ-н талаар ярилцдаггүй байна. ЕБС-д суралцаж байхдаа үзсэн НҮЭМ-н хичээл нь 50.9%-д өнөөгийн амьдралд нь хангалтгүй мэдлэг болсон гэж хариулжээ. Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт нь залуусын дунд 77.6% нь их байна гэж хариулсан. **Дүгнэлт:** Эрэгтэй оюутнуудын ГБТ болон орчин үеийн ЖСА-н талаарх мэдлэг хангалтгүй байв.

Үндэслэл: Монгол Улс сүүлийн 20 жилийн хугацаанд эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах талаар нэлээд ахиц дэвшил гаргасан. Гэсэн хэдий ч ГБТ-н эрэлтийг хангах явдал буурч, үр хөндөлтийн тоо болон БЗХӨ-н тархалт өндөр хэвээр байгаа нь ГБТ-н хангагдаагүй хэрэгцээг бууруулах арга хэмжээг эмэгтэйчүүдэд төдийгүй эрэгтэйчүүдэд ч цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь манай улсад төдийгүй дэлхийн бусад оронд тулгамдсан асуудлын нэг болоод байна. Тухайлбал: Иран улсын ИС-н оюутнуудын асуумж судалгаагаар нийт эрэгтэй, эмэгтэй оюутнуудын нөхөн үржихүйн мэдлэгийн түвшин 54%-тай байсан бол судалгаанд оролцогчдын 82% нь жирэмслэлтээс хамгаалах эмийн тухай мэддэг гэсэн бол, ердөө 17% нь яаралтай ууж жирэмслэлтээс сэргийлэх эмийн талаар мэдлэгтэй байв[1]. 2019 онд АНУ-н 18-30 насны 900 эрэгтэйчүүдэд хийсэн судалгаагаар 18-19 насны эрэгтэйчүүдийн 26.2% нь бэлгийн харилцаанд орохдоо жирэмслэлтээс хамгаалах эм, хэрэгслийг хэрэглэдэг, 20-24 насны эрэгтэйчүүдийн 39.3% нь бэлгийн харилцаанд орохдоо жирэмслэлтээс хамгаалах эм, хэрэгслийг тогтмол хэрэглэдэг гэсэн нь

эрэгтэйчүүд жирэмслэлтээс хамгаалах эмийн талаар мэдлэг дутмаг байгаа нь харагдаж байна[2]. Манай улсад 2019 онд бэлгийн замаар дамжих халдварын 17.9 мянган тохиолдол илэрч сүүлийн 10 жилийн дунджаас 2.5 мянга буюу 16.4 хувиар, өмнөх оноос 1.7 мянга буюу 10.8 хувиар өссөн байв[4]. 2018 оны байдлаар үр хөндөлтийн 15.822 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 204.0, нөхөн үржихүйн насны 1 000 эмэгтэйд 18.8% үр хөндөлт ногдож байсан бол 15-49 насны эмэгтэйчүүдийн 56.5% ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг байна[4]. Манай оронд эрчүүдийг хамарсан НҮЭМ-н судалгаа ховор бөгөөд 1998, 2003, 2007, 2017 онуудад хийгдсэн судалгаанд[3] ГБТ, ЖСА хэрэгсэл, ДОХ/ БЗХӨ-н талаар асуумж авсан боловч, гол төлөв эмэгтэйчүүдийн хувьд дүгнэсэн байв. НҮЭМ тулгамдсан асуудлууд болох үргүйдэл, цэвэршилт, эрчүүдийн бэлгийн болон НҮЭМ-н асуудал олон жил орхигдсон хэвээр байна. НҮЭМ асуудалд дан ганц эмэгтэйчүүдийн оролцоо бус, эрчүүдийн оролцоо, тэдний гэр бүл төлөвлөлтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, мэдлэг, дадлага, хандлагыг дээшлүүлэх шаардлагатай байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Их сургуульд суралцаж байгаа 18-24 насны эрэгтэй оюутнуудын ГБТ, НҮЭМ талаарх мэдлэгийг тодорхойлох.

Судалгааны арга, аргачлал: Судалгааг нэг агшингийн загварыг ашиглан хийж ДХИС, БХИС, ХААИС, АШУҮИС, МУИС, ШУТИС-н 18-24 насны эрэгтэй оюутнуудыг төлөөлөх чадвартай /460/ оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч хамруулсан бөгөөд судалгааны асуумжийг онлайнаар авлаа. Судалгааны асуумжийн мэдлэгийг үнэлэх асуултууд дээр зөв хариулт болгон 1 оноо, буруу болон мэдэхгүй гэсэн хариултууд нь 0 оноо гэж үнэлсэн. Нийт мэдлэгийг муу буюу хангалттгүй: 7-с доош, дунд: 7-9, сайн: 10-13 гэж оноожуулав. Судалгааны мэдээлэлд SPSS-25 программыг ашиглан боловсруулалт хийв.

Үр дүн: Судалгаанд нийт 460 эрэгтэй оюутнууд хамрагдсанаас дундаж нас нь 20.3 байв. Бэлгийн харилцаанд орсон ба ороогүй бүлгийг оюутнуудын насны бүлэгтэй харьцуулахад статистикийн үнэн магадлал бүхий ялгаатай байв (p=0.001). Хоёр бүлэг нь тохиолдлын бэлгийн хавьталд бэлгэвч тохиромжтой гэсэн мэдлэгийн үр дүнтэй харьцуулахад статистик үнэн магадлалтай байв (p=0.001). Бэлгийн харилцаанд орсон ба ороогүй бүлэг нь жирэмслэлтээс яаралтай ууж хамгаалах 72 цагийн эм бэлгийн харилцаанд орсны дараа ууж жирэмслэлтээс хамгаална гэсэн мэдлэгийн үр дүнтэй харьцуулахад статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байв (p=0.001) (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын нөхөн үржихүйн талаархи мэдлэг

Үзүүлэлт	N	Бэлгийн харьцаанд орсон бүлэг	Бэлгийн харьцаанд ороогүй бүлэг	P утга
Насны бүлэг				
18-20	273	187	86	0.001
21-24	187	166	21	
Биений юмны мөчлөгийн дунд үед эмэгтэй хүн бэлгийн харьцаанд орвол жирэмслэнэ				
Тийм	213	174(81.7)	34(18.3)	0.001
Үгүй	83	69(83.1)	14(16.9)	
Мэдэхгүй	164	109(66.5)	55(33.5)	
Бэлгэвч БЗХӨ*-с сэргийлж чадна				
Тийм	407	321(78.9)	86(21.1)	0.002
Үгүй	8	6(75)	2(25)	
Мэдэхгүй	45	25(55.6)	20(44.4)	
ЯУЖСЭ* бэлгийн харьцаанд орсны дараа ууж жирэмслэлтээс хамгаална				
Тийм	229	193(84.3)	36(15.7)	0.0001
Үгүй	46	34(73.9)	12(26.1)	
Мэдэхгүй	185	125(67.6)	60(32.4)	
Таны хувьд жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслүүдээс аль нь хамгийн тохиромжтой гэж үздэг				
Бэлгэвч	388	300(77.3)	88(22.7)	0.051
Эм	9	7(100)	2	
Хуанли хөтлөх	19	15(78.9)	4(21.1)	
Суулгац	24	19(79.2)	5(20.8)	
Ерөндөг	3	3(100)	0	
Бусад (Гадуур тавих, эр, эм стерилизаци, гель хэрэглэх)	17	8(47.1)	9(52.9)	

БЗХӨ* бэлгийн замын халдварт өвчин; ЯУЖСЭ* яаралтай ууж жирэмслэлтээс сэргийлэх эм

Бэлгийн харилцаанд орсон ба ороогүй хоёр бүлгийн нөхөн үржихүйн талаарх мэдлэгийн оноог харьцуулахад бэлгийн харилцаанд орсон бүлгийн 7.7% нь сайн, 47.7% нь дунд, 44.6% нь муу мэдлэгтэй байсан бол бэлгийн харилцаанд ороогүй бүлэг нь 60.2% нь хангалтгүй түвшний мэдлэгтэй байв. Хоёр бүлгийн нөхөн үржихүйн талаарх оноожуулсан мэдлэгийн түвшинг насны бүлэгтэй харьцуулахад статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байлаа (p=0.001) (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Бэлгийн харилцаанд орсон ба ороогүй бүлгийн нөхөн үржихүйн талаархи мэдлэгийг үнэлсэн онооны харьцуулалт

Үзүүлэлт	N	Мэдлэгийн түвшин			P утга
		Сайн (10-13 оноо)	Дунд (7-9 оноо)	Муу (7 доош оноо)	
Насны ангилал					
18-20	273	12(4.4)	111(40.7)	150(54.9)	0.001
21-24	187	18(9.6)	97(51.9)	72(38.5)	
Бэлгийн харьцаанд орж байсан бүлэг	352	27(7.7)	168(47.7)	157(44.6)	0.01
Бэлгийн харьцаанд орж байгаагүй бүлэг	108	3(2.8)	40(37)	65(60.2)	

Гэр бүл төлөвлөлтийн талаар оюутнуудын ойлголтыг шалгахад та хэзээ, хэдэн хүүхэдтэй болох тухайгаа эхнэр, найз охинтойгоо ярилцдаг талаархи ойлголт нь насны бүлэгтэй харьцуулахад статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байв (p=0.001) (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын гэр бүл төлөвлөлтийн талаархи ойлголт

Асуулт	N	Насны бүлэг		P утга
		18-20	21-24	
Та хэзээ, хэдэн хүүхэдтэй болох тухай /эхнэр, найз охинтойгоо/ ярилцдаг уу?				
Тийм	284	155(54.6)	129(45.4)	0.01
Үгүй	111	79(71.2)	32(28.8)	
Мэдэхгүй	65	39(60)	26(40)	
Ямар нөхцөл бүрдсэн үед хүүхэдтэй болъё гэж боддог вэ?				
Их сургуулиа төгсөөд	44	27(61.4)	17(38.6)	0.22
Тогтсон ажилтай болоод	249	144(57.8)	105(42.2)	
Байр машинтай болоод	103	69(61.1)	34(41.9)	
Бусад	64	33(51.6)	31(48.4)	
Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого явуулдаг гэдгийг та мэдэх үү?				
Тийм	192	109(56.8)	83(43.2)	0.55
Үгүй	137	86(62.8)	51(37.2)	
Мэдэхгүй	131	78(59.5)	53(40.5)	
Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт өсвөр үе, залуусын дунд хэр их байна гэж бодож байна вэ?				
Их	357	208(58.3)	149(41.7)	0.678
Бага	19	12(63.2)	7(36.8)	
Мэдэхгүй	84	53(63.1)	31(36.9)	

Хэлцэмж: Бид энэхүү судалгаагаар оюутнуудын НҮЭМ, ГБТ-н талаархи мэдлэгийн түвшинг тодорхойлж нөхөн үржихүйн үзүүлэлт бусад хүчин зүйлсийн хамаарлыг судлав. Манай оронд эрэгтэй оюутнуудын НҮЭМ, ГБТ-н талаархи мэдлэгийг тодорхойлсон судалгаа байхгүй байна. 2008 онд Турк улсын их сургуульд суралцагч эрэгтэй оюутнуудын дунд яаралтай ууж жирэмслэлтээс хамгаалах эм болон гэр бүл төлөвлөлтийн талаар асуумж судалгааг авахад нийт оюутнуудын 14.5% нь яаралтай ууж жирэмслэлтээс хамгаалах эмийн талаар сонсож байсан гэж хариулсан бол, 79.4% нь ГБТ-н талаар мэддэг, харин 69.5% нь бэлгийн харилцаанд орохдоо бэлгэвчийг хэрэглэдэг гэж хариулсан байгаа бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байв[5]. Мөн Босни улсад хийгдсэн 19-24 насны залуучуудын дунд хийгдсэн судалгаагаар 61% нь бэлгийн идэвхитэй амьдралтай, 74% нь бэлгэвч хэрэглэдэг боловч бусад жирэмслэлтээс сэргийлэх аргуудын талаар 51.6% нь л мэдэж байсан ба судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн 4.9% нь үр хөндөлт хийлгэсэн байна[6]. Харин манай судалгаанд оролцогчдын бэлгийн харилцаанд орсон оюутнуудын 77.3% бэлгэвчийг хэрэглэдэг байна. Манай судалгаанд оролцогчдын бэлгийн харилцаанд орсон ба ороогүй хоёр бүлгийн нөхөн үржихүйн талаарх мэдлэгийг оноожуулан харьцуулахад бэлгийн харилцаанд орсон бүлгийн 7.7% нь сайн, 47.7% нь дунд, 44.6% нь муу түвшний мэдлэгтэй байсан бол бэлгийн харьцаанд ороогүй бүлгийн 2.8% нь сайн, 37% нь дунд, 60.2% нь муу түвшний мэдлэгтэй байв. 2015 онд Австралид хийгдсэн судалгаанд 14-24 насны 119 өсвөр үеийнхэн, эрэгтэйчүүдийг хамруулж, жирэмслэлтээс хамгаалах эм, хэрэгслийн талаарх мэдлэгийг шалгахад, судалгаанд оролцогчдын 82% нь бэлгэвчний хэрэглээг сайн мэддэг, нийт судалгаанд оролцогчдын 26% нь бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ) талаар сайн мэдлэгтэй байсан бол, жирэмслэлтээс хамгаалах дааврын бэлдмэлийн хэрэглээг 23% нь мэддэг гэж хариулсан нь манай судалгааны үр дүнтэй дүйж байна. Манай орны хувьд бүх насны эрчүүдийн эрүүл мэнд тэр дундаа НҮЭМ, ГБТ-н талаархи судалгааг цаашид хийх шаардлагатай байна.

Дүгнэлт: Их сургуулийн эрэгтэй оюутнуудын ГБТ болон нөхөн үржихүйн талаарх мэдлэгийн түвшин хангалтгүй байна.

Ном зүй:

1. *1. Simbar M, Tehrani F, Hashemi ZJE-EMHJ, 11, 888-897,. Reproductive health knowledge, attitudes and practices of Iranian college students. 2005.*
2. *2. Lundsberg LS, Pal L, Gariepy AM, Xu X, Chu MC, Illuzzi JLJF, et al. Knowledge, attitudes, and practices regarding conception*

and fertility: a population-based survey among reproductive-age United States women. 2014;101(3):767-74. e2.
3. *Эрүүл мэндийн үзүүлэлт 2018 Эрүүл мэндийн хөгжлийн төв УБ 2018 хуудас 50, хуудас 78-79*
4. *Эрүүл мэндийн үзүүлэлт 2019 Эрүүл мэндийн хөгжлийн төв УБ 2019 хуудас 60-61, хуудас 127-129*
5. *Saraçoğlu GV, Erdem İ, Doğan S, Tokuc BJNPA. Youth sexual health: Sexual knowledge, attitudes, and behavior among students at a university in Turkey. 2014;51(3):222.*
6. *Hadžimehmedović A, Jahić M, Muratović SJMp. Knowledge, attitudes and practices among the youth in Bosnia and Herzegovina relevant for reproductive health. 2017;70 (9-10):289-96.*
7. *Ritter T, Dore A, McGeechan KJA, health NZjop. Contraceptive knowledge and attitudes among 14–24-year-olds in New South Wales, Australia. 2015;39(3):267-9.*

Determining family planning and reproductive knowledge of male students

Badrangui B[1], Enkhtsetseg J[2], Amarsaikhan D[1], Bayarmagnai L[3], Khorolsuren L[4], Oyunbileg D[5], Myadagmaa J[1]

[1]Department of Preventive Medicine, School of Public Health, MNUMS
[2]Department of Obstetrics and Gynecology, School of Medicine, MNUMS
[3]Department of Epidemiology and Biostatistics School of Public Health, MNUMS
[4]Department of Health Policy, School of Public Health, MNUMS
[5]Department of Health Social work and Social Sciences, School of Public Health, MNUMS
Email: badraa59@gmail.com, Tel: 95140163, 99950077

Objective: To determine the knowledge of reproductive health and family planning of male students aged between 18-24 studying in Mongolian universities.
Methods: The survey was conducted by cross sectional. Data were obtained online from male students at the universities using standard WHO questionnaires.
Results: The study involved 460 university students, with an average age of 20.03 and 60.4% of the respondents were single and 4.6% were married. 76.5% of the participants had sexual intercourse. Comparing the reproductive knowledge scores of both sexually active and non-sexually active groups, 7.7% of the sexually active group had good knowledge, 47.7% had moderate knowledge, 44.6% had poor knowledge, and 60.2% of the non-sexual group had insufficient knowledge (p=0.001). 56.1% of respondents do not talk to their parents about reproductive health. 84.3% of them attended reproductive health programs at high school, and 50.9% answered that the knowledge they were learning was insufficient for their current condition. When asked how high the number of unwanted pregnancies and abortions is among young people, 77.6% said it is high.
Conclusion: Male students aged between 18-24 have inadequate knowledge of family planning and modern contraceptives.

Keywords: Reproductive health, male students, family planning, contraception, abortion